

ИРГЭДЭЭС 2023 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРАЛД ЦАГДАА, ДОТООДЫН
ЦЭРГИЙН АНГИ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН САНАЛ,
ХҮСЭЛТ, ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН МЭДЭЭ

2023 оны 04 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

***Нэг. Иргэд, байгууллагаас цагдаагийн байгууллага,
албан тушаалтанд гаргасан санал, өргөдөл, гомдлын
шийдвэрлэлтийн талаар***

Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын удирдах албан тушаалтанд 2023 оны 1 дүгээр улиралд иргэд, байгууллагаас 5037 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 639 нэгжээр буюу 12.7 хувиар буурчээ.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 106 буюу 2.1 хувь нь санал, 4890 буюу 97.1 хувь нь өргөдөл, 41 буюу 0.8 хувь нь гомдол байна.

Санал, өргөдөл, гомдлыг утгаар нь авч үзвэл: 293 буюу 5.8 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 94 буюу 1.9 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 660 буюу 13.1 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 781 буюу 15.5 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 109 буюу 2.2 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 3100 буюу 61.5 хувь нь бусад өргөдөл, гомдол байна.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 4924 буюу 97.8 хувийг шийдвэрлэж, 113 буюу 2.2 хувь нь ажиллагаанд байна.

***Хоёр.Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад иргэд,
байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг
шийдвэрлэсэн талаар***

Мөн хугацаанд Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад иргэд, байгууллага, алба хаагчдаас 175 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 69 нэгжээр буюу 39,4 хувиар өсчээ.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 155 буюу 88.6 хувь нь өргөдөл, 18 буюу 10.3 хувь нь гомдол, 2 буюу 1.1 хувь нь санал байна.

Иргэд, байгууллагаас цагдаагийн албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг утгаар нь авч үзвэл: 22 буюу 12.6 хувь нь ажилд орох суралцахыг хүссэн, 18 буюу 10.3 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 20 буюу 11.4 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 8 буюу 4.6 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 31 буюу 17.7 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 76 буюу 43.4 хувь нь бусад өргөдөл, гомдол байна.

***Гурав. Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д
ирсэн санал хүсэлт, гомдол, шүүмжлэлийн талаар***

2023 оны 1 дүгээр улиралд иргэдээс Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 302 санал, гомдол, талархал, ирүүлсний 44 буюу 14.6 хувь нь санал, 239 буюу 79.1 хувь нь гомдол, 19 буюу 6.3 хувь нь талархал байна.

Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэлийн 264 буюу 87.4 хувийг шийдвэрлэж, 38 буюу 12.6 хувийг холбогдох алба, нэгжид судалж байна.

***Дөрөв. Иргэд, байгууллагаас цагдаагийн алба
хаагчтай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар***

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчтай холбоотой ирүүлсэн нийт 886 өргөдөл, гомдолд 962 алба хаагчийг холбогдуулан шалгажээ. Үүний 779 буюу 81.0 хувийг офицер, 180 буюу 18.7 хувийг ахлагч бүрэлдэхүүн, 3 буюу 0.3 хувийг энгийн ажилтан эзэлж байна.

Нийт зөрчлийг төрлөөр нь авч үзвэл: 73 буюу 8.2 хувь нь хууль ёс, хүний эрх чөлөөг зөрчсөн, 151 буюу 17.0 хувь нь хэрэг материал дутуу шалгасан, 38 буюу 4.2 хувь нь хэргийн хугацаа хэтрүүлсэн, 63 буюу 7.1 хувь нь бусдыг чирэгдүүлж, танил тал харсан, 5 буюу 0.5 хувь нь хээл хахууль, шан харамж авсан, 165 буюу 18.6 хувь нь цагдаагийн алба хаагчийн харьцааны соёл, ёс зүй зөрчсөн, 33 буюу 3.7 хувь нь бусдын эрх чөлөөнд халдсан, 190 буюу 21.4 хувь нь ажлын хариуцлага алдсан, 11 буюу 1.2 хувь нь архидан согтуурсан, 2 буюу 0.2 хувь өмч хөрөнгө үрэгдүүлсэн, 111 буюу 12.5 хувь нь Эрүүгийн хэрэг хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль тогтоомж зөрчсөн, 1 буюу 0.1 хувь нь цалин, тэтгэвэр тэтгэмж буруу олгосон, 43 буюу 4.8 хувь нь бусад зөрчлүүд эзэлж байна.

Нийт хүлээн авсан 886 өргөдөл, гомдлоос 775 буюу 87.5 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 111 буюу 12.5 хувьд нь хуулийн хугацаанд шалгалтын ажиллагаа явуулж байна.

ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТЭС